

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН
ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/I улирал/

2024.04.10

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9 дүгээр хавсралтын дагуу Улсын бүртгэлийн байгууллагын мэдээллийн ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд 2024 оны I улирлын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг танилцуулж байна.

**МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ХЭРЭГЖИЛТИЙГ
ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ**

| № | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|------|
| Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал | | | |
| 1.1. | Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн; | Байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт бүрэн байршуулсан байна. https://burtgel.gov.mn/%D0%B7%D0%BE%D1%80%D0%B8%D0%BB%D0%B3%D0%BE#block-83807 | 100 |
| 1.2. | Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг; | Байгууллагын цахим хуудасны “Танилцуулга” цонхонд байршуулсан байна. https://burtgel.gov.mn/butets https://burtgel.gov.mn/gazar-heltsiin-jagsaalt | 100 |
| 1.3. | Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж; | Байгууллагын цахим хуудасны ил тод цонхны дотоод аудит цэсэд байршуулсан байна. https://burtgel.gov.mn/post/63621 https://burtgel.gov.mn/%D0%B4%D0%BE%D1%82%D0%BE%D0%BE%D0%B4-%D0%B0%D1%83%D0%B4%D0%B8%D1%82 | 100 |
| 1.4. | Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан; | 2015 оны Хууль тогтоомжийн тухай хуулийн 51.3.-т хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд | 100 |

| | | | |
|------|--|---|-----|
| | | шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно гэж заасны дагуу 2020 онд Улсын бүртгэлийн багц хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний тайланг байршуулсан ба дараагийн хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх хугацаа болоогүй. https://burtgel.gov.mn/post/62293 | |
| 1.5. | Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан; | Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд жилд 2 удаа дээд газарт хүргүүлдэг. Тайланг жилд 2 удаа буюу 02 сар 07 сард Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим хуудсанд байршуулдаг. https://burtgel.gov.mn/%D1%85%D3%A9%D0%B3%D0%B6%D0%BB%D0%B8%D0%B9%D0%BD-%D0%B1%D0%BE%D0%B4%D0%BB%D0%BE-%D0%B3%D0%BE-%D1%82%D3%A9%D0%BB%D3%A9%D0%B2%D0%BB%D3%A9%D0%BB%D1%82%D0%B8%D0%B9%D0%BD-%D0%B1%D0%B0%D1%80%D0%B8%D0%BC%D1%82-%D0%B1%D0%B8%D1%87%D0%B8%D0%B3-%D1%82%D2%AF%D2%AF%D0%BD%D0%B8%D0%B9-%D1%85%D1%8D%D1%80%D1%8D%D0%B3%D0%B6%D0%B8%D0%BB%D1%82%D0%B8%D0%B9%D0%BD-%D1%82%D0%B0%D0%B9%D0%BB%D0%B0%D0%BD | 100 |
| 1.6. | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт; | Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй эрх зүйн актын судалгааг 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр шинэчлэн гаргасан бөгөөд улсын бүртгэлийн үйл ажиллагаанд одоогийн байдлаар Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаас баталсан нийт 97 эрх зүйн акт шууд үйлчилж байна. "Хууль эрх зүй-Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөгдөх эрх зүйн актууд" https://burtgel.gov.mn/%D0%B1%D1%83%D1%81%D0%B0%D0%B4 | 100 |
| 1.7. | Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, | "Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 221 дүгээр тогтоолын 20 дугаар хавсралтаар баталсан Албан тушаалын тодорхойлолт" болон албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах | 100 |

| | | | |
|--|--|--|-----------|
| | албаны цахим шуудангийн хаяг; | утасны дугаар, албаны цахим шуудангийн хаягийг байгууллагын цахим хуудасны танилцуулга цонхны газар, хэлтэс хэсэгт, байршуулсан. "Танилцуулга-Газар хэлтэс" https://burtgel.gov.mn/gazar-heltsiin-jagsaalt | |
| 1.8. | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ; | 2023 онд Улсын бүртгэлийн ерөнхий газарт ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд хяналт-шинжилгээ хийсэн ажлын тайланг цахим хуудаст байршуулсан; "Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ цэсэнд байршиж байна" https://burtgel.gov.mn/post/64652 Говьсүмбэр, Дорноговь, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Хөвсгөл, Хэнтий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсүүд 2023 оны II, III, IV улирлын өргөдөл гомдлын мэдээг цахим хуудаст байршуулаагүй байна. | 65.2 |
| 1.9. | Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл; | Улсын бүртгэлийн байгууллагын сар бүрийн статистик мэдээг батлагдсан хүснэгтийн дагуу бэлтгэн байгууллагын цахим хуудаст байршуулсан байна. https://burtgel.gov.mn/post/64596 Булган, Говьсүмбэр, Өвөрхангай, Сүхбаатар, Увс, Орхон, Сэлэнгэ, Хэнтий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсүүд 2024 оны 1,2,3 дугаар сарын статистик мэдээг цахим хуудаст байршуулаагүй байна. | 65.2 |
| 1.10. | Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр; | Байгууллагын цахим хуудас болон аймаг, дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн цахим хуудаст тухай бүр байршуулсан байна. https://burtgel.gov.mn/%D1%86%D0%B0%D0%B3-%D2%AF%D0%B5-%D2%AF%D0%B9%D0%BB-%D1%8F%D0%B2%D0%B4%D0%B0%D0%BB | 100 |
| Хэсгийн дундаж хувь: | | | 93 |
| Хоёр.Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал | | | |
| 2.1. | Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл; | Байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалын тусгай шалгалтын сонгон шалгаруулалтын мэдээллийг тухай бүр хүний нөөцийн ил тод байдал цонхонд байршуулсан байна. https://burtgel.gov.mn/shiljuuleh-selgen-ajilluulah Говь-Алтай, Говьсүмбэр, Өвөрхангай, Завхан, Сэлэнгэ, Ховд, Хэнтий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсүүд ажлын байрны сул орон тооны мэдээллийг хэлтсийн цахим хуудсанд байршуулж хэвшээгүй байна. | 70 |

| | | | |
|------|---|--|-----|
| 2.2. | Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам; | Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам, загварыг байгууллагын цахим хуудасны хүний нөөцийн ил тод байдал цонхонд байршуулсан байна. https://burtgel.gov.mn/post/62923 | 100 |
| 2.3. | Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм; | Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг байгууллагын цахим хуудасны ил тод цонхны “Ёс зүйн зөвлөлийн мэдээлэл” хэсэгт байршуулсан байна. https://burtgel.gov.mn/uploads/users/2261/files/yos_zuin_durem.PDF | 100 |
| 2.4. | Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам; | Төрийн албаны тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн даргын 2022.02.22-ны өдрийн 27 дугаар тушаалаар Улсын бүртгэлийн байгууллага хүний нөөцийн үйл ажиллагаандаа чадахуйн зарчмыг хэрэгжүүлж байгааг үнэлж дүгнэх, төрийн албаны шинэтгэл, хүний нөөцийн менежмент, төрийн албаны чадавхыг бэхжүүлэх чиглэлээр арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилготой аудитын баг байгуулагдаж тус байгууллагад хүний нөөцийн аудит хийсэн талаарх мэдээллийг 2022.05.17 цахим хуудаст байршуулсан. “Ил тод байдал-Хүний нөөцийн ил тод байдал” https://burtgel.gov.mn/post/61109 | 100 |
| 2.5. | Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ; | Улсын бүртгэлийн байгууллагын www.burtgel.gov.mn цахим хуудасны “Хүний нөөцийн ил тод байдал” цонхонд мэдээлэл байршуулаагүй байна. https://burtgel.gov.mn/%D1%85%D2%AF%D0%BD%D0%B8%D0%B9-%D0%BD%D3%A9%D3%A9%D1%86%D0%B8%D0%B9%D0%BD-%D1%83%D0%B4%D0%B8%D1%80%D0%B4%D0%BB%D0%B0%D0%B3%D1%8B%D0%BD-%D0%B8%D0%BB-%D1%82%D0%BE%D0%B4-%D0%B1%D0%B0%D0%B9%D0%B4%D0%B0%D0%BB?page=0 | 50 |

| | | | |
|---|---|---|-------------|
| 2.6. | Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам. | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 08 сарын 23-ны өдрийн 301 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"8 "ЗГХЭГ-ын даргын 2023 оны 98 дугаар тушаалаар батлагдсан аргачлал, загвар"-ыг УБЕГ-ын цахим хуудасны "Хүний нөөцийн ил тод байдал" цонхны "Бусад" хэсэгт байршуулсан байна. https://burtgel.gov.mn/post/63649 НУБГ, Орон нутгийн Улсын бүртгэлийн хэлтсүүд "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ыг шинэчлэн байршуулаагүй байна. /Булган, Дундговь аймгийн улсын бүртгэлийн хэлтэс дээрх журмыг байршуулсан/ | 50 |
| Хэсгийн дундаж хувь: | | | 78.3 |
| Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал | | | |
| 3.1. | Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл; | НУБГ болон Орон нутгийн улсын бүртгэлийн хэлтэс өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төслийг шилэн дансанд байршуулсан. https://shilendans.gov.mn/organization УБЕГ байгууллагын батлагдсан төсвийг шилэн дансанд хугацаа хоцроож байршуулсан байна. | 95 |
| 3.2. | Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан; | Төсвийн гүйцэтгэл, хагас бүтэн жилийн санхүүгийн тайланг шилэн дансанд байршуулсан байна. https://shilendans.gov.mn/organization | 100 |
| 3.3. | Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт; | УБЕГ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдөр цахим хуудасны санхүүгийн ил тод цонхонд байршуулсан байна. https://burtgel.gov.mn/post/62890 | 100 |
| 3.4. | Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ; | Байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийн мэдээллийг сар бүр шилэн дансанд байршуулсан байна. https://shilendans.gov.mn/organization | 100 |
| 3.5. | Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар; | Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгааныг цахим хуудасны шилэн данс цонхонд сар бүр байршуулсан байна. https://burtgel.gov.mn/post/63445 | 100 |

| | | | |
|-------|--|--|-----|
| 3.6. | Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; | Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг байгууллагын цахим хуудасны шилэн данс цонхонд байршуулсан байна. https://burtgel.gov.mn/hudaldan-awah-ajillagaanii-il-tod https://shilendans.gov.mn/organization | 100 |
| 3.7. | Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт; | Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг сар бүр байгууллагын цахим хуудасны шилэн данс цонхонд байршуулсан байна. https://burtgel.gov.mn/sanhuugiin-il-tod-baidal https://shilendans.gov.mn/organization | 100 |
| 3.8. | Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр; | Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг сар бүр шилэн дансанд байршуулсан байна. https://shilendans.gov.mn/ | 100 |
| 3.9. | Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл; | Байгууллагын цахим хуудасны шилэн данс цонхонд байршуулсан байна. https://shilendans.gov.mn/organization/45819 | 100 |
| 3.10. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан | Хөрөнгө оруулалтын төсвөөр худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээллийг байгууллагын цахим хуудасны худалдан авах ажиллагааны ил тод байдал цонхонд байршуулсан байна. https://burtgel.gov.mn/hudaldan-awah-ajillagaanii-il-tod https://shilendans.gov.mn/organization | 100 |

| | | | |
|--|---|--|-------------|
| 3.11. | Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт; | Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлтийн талаарх мэдээллийг тухай бүр цахим хуудаст байршуулсан байна. 2023 оны худалдан авах ажиллагаанд аудитын шалгалт явагдаж байна. https://burtgel.gov.mn/hudaldan-awah-ajillagaanii-il-tod | 100 |
| 3.12. | Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл; | Улсын бүртгэлийн ерөнхий газар буюу захиалагч бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд гэрээ ба түүний нөхцөл, эдгээртэй холбогдуулж захиалагчийн өгсөн техникийн тодорхойлолт, зураг, загвар, дээж зэрэг мэдээллийг гэрээг гүйцэтгэхээр томилогдсон ажилтнаас бусад этгээдэд задлахгүй байх талаар тендер оролцогчдод анхааруулж, нууцын баталгаа гаргуулан, техникийн тодорхойлолтын талаар мэдээллээр тухай бүр ажлын хэсгээс ханган ажилласан байна. | 100 |
| 3.13. | Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн; | Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүнг цахим хуудасны “Шилэн данс” болон “Ил тод байдал” цонхны “Төсөл, хөтөлбөр” хэсэгт байршуулсан байна. https://burtgel.gov.mn/post/60730 | 100 |
| 3.14. | Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан; | УБЕГ-ын 2023 оны үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээ хийсэн судалгааны тайланг 2023.12.12-ны өдөр байршуулав. https://burtgel.gov.mn/post/64232 | 100 |
| 3.15. | Хууль тогтоомжид заасан бусад. | Цахим хуудаст бүрэн байршуулсан байна. | 100 |
| Хэсгийн дундаж хувь: | | | 99.6 |
| Дөрөв.Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал | | | |
| 4.1. | Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл; | ИУБГ, ЭХЭУБГ, ХЭУБГ, УБНА-ын газраас иргэдэд үзүүлдэг үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл зэргийг хянаж /2022.10.01/ шинэчлэн байршуулсан. Үйлчилгээний төлбөр төлөх дансны мэдээлэлд өөрчлөлт орсныг шинэчлэн байршуулсан. Энэ талаар иргэдэд мэдээлэл хүргэх зорилгоор инфографик бэлтгэн байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан. Мөн дээрх мэдээллүүдэд өөрчлөлт орсон тохиолдолд тухай бүр өөрчлөн шинэчилж байна. https://burtgel.gov.mn/post/58198 | 100 |

| | | | |
|--|---|--|------------|
| | | https://burtgel.gov.mn/service/index.php/les-newlist/les-new | |
| Хэсгийн дундаж хувь: | | | 100 |
| Тав. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал | | | |
| 5.1. | Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал; | Олон нийтээр хэлэлцүүлж, санал авсан хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөл болон батлагдсан тушаалыг тухай бүр байгууллагын цахим хуудсанд байршуулсан байна. https://burtgel.gov.mn/%D0%B8%D1%80%D0%B3%D1%8D%D0%BD%D0%B8%D0%B9-%D1%83%D0%BB%D1%81%D1%8B%D0%BD-%D0%B1%D2%AF%D1%80%D1%82%D0%B3%D1%8D%D0%BB-22788 | 100 |
| 5.4. | Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл; | СБД-ийн үйлчилгээний 2-р байрны газар нийт талбайн хэмжээ 1411мкв, газрын улсын бүртгэлийн дугаар Г-2203008931, Газар эзэмших ашиглах эрхийн гэрчилгээний дугаар 437243, ашиглах хугацаа 15 жил /2014.05.26/ Газар эзэмших гэрээний дугаар 143052/0115 Уг мэдээлэл байгууллагын цахим хуудасны Ил тод байдал цонхны Санхүүгийн ил тод байдал цэсэнд байршиж байна. https://burtgel.gov.mn/post/61107 | 100 |
| 5.9. | Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт; | Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 109 дугаар тогтоолоор Завхан, Өвөрхангай, Сүхбаатар аймгийн Мэргэжлийн хяналтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийг Улсын бүртгэлийн хэлтэст балансаас балансад шилжүүлэх ажлууд зохион байгуулагдсан. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 104 дүгээр тогтоол, Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 75 дугаар тогтоолоор Аймгийн Засаг Даргын Тамгын газрын 3 дугаар байрны 580,2 м2 талбай бүхий хэсгийг Улсын бүртгэлийн хэлтсийн мэдэлд эзэмшүүлж, хөрөнгөд бүртгэхээр шийдвэрлэсэн. Мөн Говьсүмбэр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 05 дугаар тогтоолоор Цагдаагийн газрын хуучин 507.94 мкв байрыг балансаас баланст тусган Улсын бүртгэлийн хэлтэст шилжүүлэхээр шийдвэрлэж 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдөр үйл ажиллагааг нь жигдрүүлсэн. https://burtgel.gov.mn/ УБЕГ-ын Архив, үйлчилгээний цогцолбор төвийн байр нь 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн БА-069/2021 дугаартай Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын дүгнэлт, 2021 оны 02-19/2021 дугаар | 100 |

| | | | |
|----------------------------|--|---|------------|
| | | Барилга байгууламжийн ашиглалтын ногоон гэрчилгээтэй болно. Уг мэдээлэл байгууллагын цахим хуудасны Ил тод байдал цонхны Санхүүгийн ил тод байдал цэсэнд байршиж байна. /2022.05.17/ https://burtgel.gov.mn/post/61108 | |
| 5.11. | Нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл; | Тус газраас нээлттэй өгөгдлийн жагсаалтын саналыг 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 1/3568 дугаар албан бичгээр Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн. Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 232 дугаар тогтоолын хавсралтаар “Нээлттэй өгөгдлийн жагсаалт” батлагдсан. Тус байгууллагын жагсаалт 346-351 дэх хэсэгт тусгагдсан. Улсын бүртгэлийн нээлттэй мэдээллийн систем болох улсын бүртгэлийн нээлттэй мэдээллийн систем /opendata.burtgel.gov.mn/ дэх мэдээлэл бүртгэлд өөрчлөлт орсон даруйд тогтмол шинэчлэгдэж байна. | 100 |
| 5.12. | Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн нэр, эцэг /эх-ийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн; | Одоогийн байдлаар Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцаж байгаа албан хаагч байхгүй. | (-) |
| 5.13. | Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл; | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд тус газраас холбогдох мэдээллийг тухай бүр байгууллагын цахим хуудаст байршуулан ажиллаж байна. | 100 |
| Хэсгийн дундаж хувь | | | 100 |

ДҮГНЭЛТ

Улсын бүртгэлийн байгууллагын мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.8-д “Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6-д заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг олон нийтэд хүргэхдээ цахим хуудас, мэдээллийн самбар, мэдээллийн бусад хэрэгсэл ашиглана”, 8.12-д “Мэдээллийн бусад хэрэгсэл ашиглаж байгаагаас үл хамааран мэдээлэл хариуцагч цахим хуудас, мэдээллийн самбарыг заавал ажиллуулах ба цахим хуудсаар нээлттэй мэдээлэлтэй танилцах нөхцөлийг бүрэн хангана” гэж заасны дагуу Улсын бүртгэлийн байгууллагын нээлттэй мэдээллийг <https://burtgel.gov.mn/> , <https://www.facebook.com/ulsyn.burtgel/> цахим хуудас, мэдээллийн самбараар дамжуулан олон нийтэд хүргэж байна.

- Шил ажиллагаа буюу <https://shilen.gov.mn/> цахим хуудсанд УБЕГ-ын нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ 93 хувь үнэлэгдсэн бөгөөд уг үнэлгээ нэмэгдэхгүй байгаа нь мэдээ, мэдээлэл шинэчлэгдэхгүй, тогтоосон хугацаанд мэдээ, мэдээллийг байршуулахгүй байгаатай холбоотой юм.

- Булган, Говьсүмбэр, Дорноговь, Өвөрхангай, Увс, Орхон, Сэлэнгэ, Хөвсгөл, Хэнтий аймгийн улсын бүртгэлийн хэлтсүүд цахим хуудсанд улирал, хагас жил, сар бүр, тухай бүр байршуулах нээлттэй мэдээллүүдийг цаг тухайд нь шинэчлэн байршуулж хэвшээгүй байна.

| № | Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийн үзүүлэлтүүд | Үнэлгээ |
|---------------|---|-------------|
| 1 | Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал | 93 |
| 2 | Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал | 78.3 |
| 3 | Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал | 99.6 |
| 4 | Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал | 100 |
| 5 | Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал | 100 |
| Дундаж | | 94.2 |

ЗӨВЛӨМЖ

Улсын бүртгэлийн байгууллагын мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийг сайжруулах зорилгоор дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

- “Нийтийн мэдээллийг ил тод байдлын тухай хууль”-ийн 5.1.3, 5.1.4, 5.1.6-д заасан шалгуур үзүүлэлтийг хангахгүй байгаа тул газар, хэлтсүүд хариуцсан нээлттэй мэдээллийг байршуулах хугацаа, давтамжийн дагуу байршуулахад анхаарч ажиллах;

- Шил ажиллагаа буюу <https://shilen.gov.mn/> цахим хуудас шинэчлэгдсэнтэй холбоотой УБЕГ-ын нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээг нэмэгдүүлэхэд анхаарч, “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуульд заасан мэдээллүүдийг цаг тухайд нь бүрэн байршуулж ажиллах;

- Говьсүмбэр, Дорноговь, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Хөвсгөл, Хэнтий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсүүд өргөдөл гомдлын тайлан, мэдээг байршуулах хугацаа, давтамжийн дагуу цахим хуудаст байршуулж хэвших;

- Булган, Говьсүмбэр, Өвөрхангай, Сүхбаатар, Увс, Орхон, Сэлэнгэ, Хэнтий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсүүд сар, улирлын статистик мэдээг байршуулах хугацаа, давтамжийн дагуу цахим хуудаст байршуулж хэвших;

- Улсын бүртгэлийн газар, хэлтсүүд цахим хуудсанд цаг үеийн мэдээ, мэдээлэл болон улирал, хагас жил, сар бүр, тухай бүр байршуулах нээлттэй мэдээллүүдийг цаг тухайд шинэчлэн байршуулж хэвших;

Удирдлагын заалт:

.....

.....

.....

.....

.....

ТАНИЛЦСАН:
ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН

ХЯНАСАН:
БТДШГ-ЫН ДАРГА
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Т.ГАНТӨМӨР

Б.ЛХАГВАСҮРЭН

БОЛОВСРУУЛСАН:
МЭРГЭЖИЛТЭН



Д.БҮРНЭЭБАЯР

---oOo---